ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 сарын 24-ний өдрийн А/92 тоот
тушаалын 2 дугаар хавсралт Маягт-10

БАТЛАВ
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.МӨНХБАТ

2024 оны ..07.. дугаар сарын ..19..

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ
Дугаар B-U2024/585

Захиалагч байгууллага:	НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 13 ДУГААР СУРГУУЛЬ
Хэрэглэгчийн нэр:	Д.БАТЦЭЦЭГ
Харилцах утас:	360318
Байршил:	БГД 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт
Зориулалт:	13 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга
Холбооны хэрэгцээ:	СУВАГЧЛАЛ ХИЙХ, 10x2 ХОСЫН КАБЕЛЬ СУУРИЛУУЛАХ

1. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгогдсон харилцаа холбооны үндсэн сүлжээ байгуулах эрхийнхээ дагуу техникийн нөхцөлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгоно. Техникийн нөхцөлгүйгээр холбооны худаг сувагчлал байгуулах, кабель татах, шилжүүлэх тохиолдолд уг барилга обьектыг техникийн комисс болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

2. **Техникийн үндсэн нөхцөл:**
   - 2.1 КШТ-36, ХШ 36104 хүрээний S-C 01-4-1-2 худгаас төлөвлөж буй барилга хүртэл 110мм **2+0 эгнээ** сувагчлалын хоолой суурилуулах ба шинээр хийх сувагчлалыг 0.8-1.0 метрийн гүнд суурилуулна.
   - 2.2 ХШ-36104 хүрээний 5-р зуутын 9-р аравтыг оролтын худгаас салаалан авч одоо байгаа болон шинээр суурилуулсан худаг сувагчлалаар татан барилгад оруулан төгсгөлийн төхөөрөмжид холбоно.
   - 2.3 Сувагчлал хооронд худаг суурилуулах зай хэмжээг 120 метрээс хэтрэхгүй байхаар тооцох ба барилгын оролтод зайлшгүй стандартын дунд худаг суурилуулна.
   - 2.4 Шинээр суурилуулах сувагчлал нь авто зам болон бусад инженерийн шугам сүлжээтэй хөндлөн огтлолцсон тохиолдолд хамгаалалтын ган хоолойд сувагчлалыг сүвлэж хамгаална.
   - 2.5 Шилэн кабель татах асуудлыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, бусад үйлчилгээ эрхлэгч оператор компаниудтай тохиролцож шийдвэрлэх.
   - 2.6 Дохиолол, домофон систем, телефон холбоо, кабелийн телевиз, интернэт, хяналтын систем, шинэ үйлчилгээний тоног төхөөрөмжүүдийг байршуулах техникийн өрөөг зайлшгүй төлөвлөх шаардлагатай.

3. **Зураг төсөлд зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцөлүүд:**
   - 3.1 Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт **MNS 6305:2012** Холбооны кабель шугамын ажлын зураг төсөл, **MNS 4908:2022** Мэдээлэл, холбооны сүлжээний гадна холбооны зургийн тэмдэглэгээ, **MNS 5532:2022** Мэдээлэл, холбооны дотоод сүлжээ дохиолол, хяналтын системийн төхөөрөмжийн тэмдэглэгээ, ерөнхий шаардлагууд болон "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 5-р зүйлд заасны дагуу гүйцэтгэх.
   - 3.2 Төлөвлөж буй барилгын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан авто зам, авто зогсоолын талбайд одоо байгаа худаг сувагчлалын байгууламж хөндлөн болон дагуу таарсан тохиолдолд **2+0 эгнээ** сувагчлалын хоолой нэмж суурилуулах, хүчитгэж хамгаалах.

3.3 Дээрх техникийн нөхцөлийн дагуу гадна холбооны ажлын зураг гүйцэтгэхдээ Технологийн удирдлага, төлөвлөлтийн газрын Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсээр техникийн шийдлийг хянуулан, зөвшилцөж батлуулна. (Утас:70112383)

4. **Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:**

4.1 Угсралт суурилуулалтын ажлыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ.

4.2 Техникийн нөхцөл, ажлын зураг төсвийн дагуу угсралтын ажил эхлэхээс өмнө Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Технологийн удирдлага, төлөвлөлтийн газрын Чанар хяналтын хэлтсээс ажил эхлэх зөвшөөрлийг авч тухайн ашиглалт хариуцсан газар, нэгжийн хяналтан дор гүйцэтгэнэ.

4.3 Газар шорооны ажил гүйцэтгэхдээ тухайн харъяалагдах Кабель шугамын тасгуудаар шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актанд хавсаргах.

4.4 Шинээр татсан кабель болон төгсгөлийн төхөөрөмжид хаягжилт бүрэн хийсэн байх.

4.5 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулж ажиллах.

4.6 Угсралт суурилуулалт хийхдээ **MNS 6668:2017** "Холбооны худаг сувагчлалын байгууламжийн техникийн үзүүлэлт, суурилуулалтын шаардлага", **MNS 5017:2023** "Харилцаа холбооны сүлжээний сувагчлалд зориулсан хуванцар хоолой, техникийн шаардлага", **MNS 5276:2013** "Холбооны кабелийн суурилуулалт ерөнхий шаардлага", **MNS 5277:2003** "Кабелийг залгах, муфтлах. ерөнхий шаардлага", **MNS 5281:2003** "Кабелийн цахилгааны үзүүлэлт.ерөнхий шаардлага", **MNS 5280:2003** "Салбар кабелийн төгсгөлийн төхөөрөмжийн суурилуулалт ерөнхий шаардлага", **MNS 6597:2021** "Холбооны кабель шугамыг авто зам, төмөр замыг хөндлөн гаргах болон гүүрийн байгууламжаар дамжуулан суурилуулахад тавих ерөнхий шаардлага" стандартуудын дагуу гүйцэтгэх.

4.7 Шинээр хийгдсэн худаг сувагчлалын байгууламжийн гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгсөн акт болон DWG файл хэлбэрээр МХС ХХК-д өгч тусгуулна.

5. **Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:**

5.1 Шинээр суурилуулсан худаг сувагчлалын байгууламжийг гүйцэтгэлийн актаар хүлээлгэн өгснөөр ашиглалтын явцад гарах засвар үйлчилгээг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь хариуцна.

5.2 Уг худаг сувагчлалын байгууламж нь цааш үргэлжлүүлэн төлөвлөх, засвар үйлчилгээ хийх, мөн харилцаа холбооны бусад үйлчилгээний зориулалтаар шилэн кабель шинээр суурилуулах зэрэг нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

6. **Техникийн нөхцөлийг:** Нийслэлийн ерөнхий боловсролын 13 дугаар сургуулийн захирлын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 46 тоот албан бичгийг үндэслэн олгов.

7. Угсралтын ажил дууссаны дараа Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн хариуцсан нэгжээр хэмжилт шалгалт хийлгэж, техникийн актаар хүлээлгэн өгснөөр сүлжээнд холбогдох боломжтой.

8. **Энэхүү техникийн нөхцөл нь батлагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна. Техникийн нөхцөлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгалтыг олгоно.**

ТАНИЛЦСАН:

ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ — А.ГАНТУЛГА

ХЯНАСАН:

ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — С.ЗОЛЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — М.ЖАРГАЛАН